

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
1-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.01.20

Газрын удирдлагын хэлтэс:

ГЗБГЗЗГ-т аймгийн 2016 оны Газрын нэгдмэл сангийн тайланг ГТ-1-ээс ГТ-9, дагалдах тайлангуудыг тоон болон бичмэл байдлаар гаргаж хүргүүлэв. Үүнд:

- ГТ-1 /Газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан/
- ГТ-2 /Газрын нэгдмэл сангийн буюу эрх зүйн байдлын тайлан/
- ГТ-3 /Газрын улсын бүртгэлийн тайлан/
- ГТ-4 /Улсын тусгай хэрэгцээний газрын тайлан/
- ГТ-5 /Газрын шилжилт хөдөлгөөний тайлан/
- ГТ-6 /Газарт учруулсан хохирлын тайлан/
- ГТ-7 /Газар хамгаалах арга хэмжээний тайлан/
- ГТ-8 /Газрын төлбөр төлөлт, ногдуулалтын тайлан/
- ГТ-9 /Монгол улсын иргэнд өмчлүүлсэн газрын тайлан/
- БОХ-1, 2
- Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын мэдээ, тайлан
- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг барьцаалсан тухай тайлан
- Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний тайлан
- Газрын хууль, тогтоомж тэдгээрийн биелэлтийн тайлан
- Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын тайлан
- Газрын маргаан, түүний шийдвэрлэлтийн тайлан
- Хүний нөөцийн тайлан
- СӨХ-дын газар ашиглалтын тайлан
- Газрын албан татварын тайлан

Аймгийн Засаг даргын 5 захирамж шинээр гарсан. Үүнд:

- Газар ашиглуулах тухай – 1
- Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах тухай-1
- Газар эзэмших эрх шилжүүлэх тухай – 2
- Газар өмчлүүлэх тухай -1 Үүнд:

Нийт 646 иргэнд 65.7 га газрыг өмчлүүлсэнээс улсын чанартай автозамын дагуу 208 иргэнд 14.56 га, шинээр 417 иргэнд 50.04 га, эзэмшиж буй газраа өмчилсөн 21 иргэнд 1.1 га газрыг тус тус өмчлүүлэв.

Газар өмчилж аваагүй тодорхойлолтыг 11 иргэнд гаргаж өгөв.

Газрын төлбөр, татварын талаар:

Газрын төлбөрт 2016 оны 12 сарын 31-ний байдлаар дүнгээр 119.7 сая төгрөгийг төвлөрүүлж 12 дугаар сарын газрын төлбөрийн орлогын мэдээг аймгийн татварын хэлтэст гаргаж өгөв. 2016 оны газрын төлбөрийн төлөвлөгөөний биелэлт 134,1 хувьтай байлаа. 2017 оны 1 сарын 20-ны өдрийн байдлаар газрын төлбөрийн орлого 427,4 мянган төгрөг байна.

Геодези, кадастрын чиглэлээр:

- Сүмбэр сумын 1, 2, 3-р багийн нутаг дэвсгэрийг харуулсан байр зүйн

зургийг албан хэрэгцээнд зориулан аймгийн Цагдаагийн хэлтэст,

- Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын кадастрын зургийг 5 иргэнд, 1 иргэний газарт хэмжилт хийж кадастрын зургийг тус тус гаргаж өгөв.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр

Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй барилга байгууламжийн нэгдсэн судалгаа болон ажлын зураггүй ашиглагдаж буй нийтийн эзэмшлийн орон сууцны барилгуудын дотор байгуулалтын /план/ зургийг гаргах ажлуудыг байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн ажиллаж байна.

1.Мэдээ, тайлан:

- ГЗБГЗЗГазарт 2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн ерөнхий архитекторын тайлан болон жижүүрийн хөтлөлтийн тайланг гарган хүргүүлсэн.

2. Зураг төслийн чиглэлээр:

- Сүмбэр сумын 1-р баг, 95, 96, 97, 98, 99, 103-р байруудад газар дээр хэмжилт хийж дотор байгуулалтын/план/ зургийг гаргаж баталгаажуулсан.
- БСУГазрын хүсэлтийн дагуу Сүмбэр сум, 2-р баг, 2-р цэцэрлэгийн цахилгааны ажлын төсвийг боловсруулсан.

3. Дараахь объектуудыг Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу байнгын ашиглалтад хүлээн авсан байна.Үүнд:

- Иргэн Я.Дамдиндоогийн үйлчилгээний барилгын өргөтгөлийн ажил
- Иргэн Ц.Сүхбаярын “Оргил уидраа” төвийн барилгын ажил
- БЗӨБЦТС ТӨХК-ний Говьсүмбэр салбар конторын барилгын ажил
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн цусны банкны засварын ажил

5. Баримт бичгийн хувьд:

- 2016 онд улсын болон орон нутаг, хувийн хэвшил, бусад төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын 33 ажлын батлагдсан зураг, төсөв, техникийн баримт бичгийг архивлан ажиллаж байна.